“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2025 оны 06 сарын 23 өдөр № 04

АНХААРУУЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

АЯНГА ЦАХИЛГААН, ҮЕР УСНЫ АЮУЛААС СЭРГИЙЛЬЕ!!!

Хэт халалт үргэлжилж байгаатай холбогдуулан гол дагуу иргэдийн хөдөлгөөн ихсэж, усанд живж, амь насаа алдах эрсдэл өндөр байгаа тул анхаарал болгоомжтой байхыг хүсье. Ойрын жилүүдэд зуны улиралд усархаг, дуу цахилгаантай аадар бороо орох, аянга цахилгаан, мөндөр, нөөлөг салхи зэрэг байгалийн аюултай үзэгдлүүд олон давтамжтайгаар гэнэтийн байдлаар манай улсын нутаг дэвсгэрт байнга тохиолдож байна. Иймд:

1. Цаг агаарын тухай сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол хүлээн авч сэрэмжлэх, бусдад дамжуулах.
2. Томилолтоор яваа ИТА нар замд хоноглохдоо уулын ам, гол усны зам, голын голдирол, гуу, жалга, хуурай сайр, ус хальдаг эрэг, үерийн буулт бүхий газарт хоноглохгүй байх.
3. Голын усны түвшин нэмэгдэж, үерийн нөхцөл байдал үүссэн үед зориулалтын гарцтай газраар буюу зөвхөн баталгаат зам гүүрээр зорчихыг зөвлөж байна.
4. Гамшгийн нөхцөл байдал хүндэрч эхлэхээс өмнө Онцгой байдлын газрын **101, 105** дугаарын утсанд яаралтай холбогдохыг анхааруулж байна!!!

Утас: 88974030
sqmd@mcaa.gov.mn